



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 512

Улаанбаатар хот

“МИК Актив Нэг” ХХК-ийн гаргаж буй  
хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.6, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 8.1 болон Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “МИК Актив Нэг” ХХК-ийн гаргаж буй 100 000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 20 хүртэл жилийн хугацаатай, нийт 3281465 /гурван сая хоёр зуун наян нэгэн мянга дөрвөн зуун жаран тав/ ширхэг хүртэл орон сууцны зээлээр баталгаажсан баталгаат үнэт цаасыг доорх хэлбэр, нөхцөлтэйгөөр үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Саруул/, төвлөрсөн хадгаламжид бүртгэж, холбогдох төлбөр тооцоог гүйцэтгэж ажиллахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай:

№	Баталгаат үнэт цаасны төрөл	Нэрлэсэн үнэ	Тоо ширхэг	Жилийн хүү	Хугацаа	Нийт хэмжээ
1	Энгийн баталгаат үнэт цаас	100 000	328 146	10,5%	20 хүртэл жил	32 814 600 000
2	Давуу эрхтэй баталгаат үнэт цаас	100 000	2 953 319	4,5%	20 хүртэл жил	295 331 900 000
	Нийт	100 000	3 281 465			328 146 500 000

2. 3281465 ширхэг хүртэл баталгаат үнэт цаасыг үнэт цаасны танилцуулгад тусгасан буюу энэ тогтоолын 1-д заасан хэмжээгээр худалдахыг “МИК Актив Нэг” ХХК-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж байгаатай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “МИК Актив Нэг” ХХК-д үүрэг болгосугай:

1/ Санхүүгийн зохицуулах хороо нь энэхүү тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэн нь тухайн үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багцад байгаа үл

000867

хөдлөх хөрөнгийн жагсаалтад байгаа мэдээлэл нь эрсдэлгүй, үнэн зөв гэсэн баталгаа биш бөгөөд хэрэв тухайн баталгаат үнэт цаасанд эрсдэл гарвал Санхүүгийн зохицуулах хороо хариуцахгүйг мэдэгдэхийн хамт энэ талаар үнэт цаасны танилцуулгад тусгайлан тэмдэглэж хөрөнгө оруулагчдад мэдээлэх;

2/ Энэхүү тогтоолын 1-д заасан баталгаат үнэт цаасыг бүртгэсэнтэй холбогдуулан уг үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн багц дахь үл хөдлөх хөрөнгийг Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2013 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн хамтарсан А/167/203 тоот тушаалаар батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийх, бүртгэх тухай журам”-д заасны дагуу Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн байгууллага дахь барьцааны бүртгэлд бүртгүүлж, энэ талаар ажлын 10 хоногийн дотор Хороонд эргэж мэдэгдэх;

3/ Баталгаат үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны тайланг 30 хоногийн дотор Хороонд ирүүлж, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөр төлөх, мэдээллээр хангах болон бусад үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллах.

4. Баталгаат үнэт цаасны борлуулалт, үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтөд холбогдох журмын дагуу хяналт тавьж, энэ талаар улирал бүр Санхүүгийн зохицуулах хороонд мэдээлж ажиллахыг “ҮЦТТГХТ” ХХК /Т.Гандулам/-д үүрэг болгосугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

Огноо:  
Хугацаа:  
Хариуцагч:  
Бүтээгч/Хариуцагч: